



МУИС–ИЙН ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ 2014 ОНД УЛААНБААТАР ХОТООС ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ¹

1. Ерөнхий зүйл

- 1.1. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2014 онд Улаанбаатар хотоос оюутан элсүүлэхэд БШУ-ны сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам” бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журмыг (цаашид журам гэнэ) баримтална.
- 1.2. МУИС-д элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтаж элсэх эрх авсан бол “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “систем” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.
- 1.4. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт нийслэл хот болон аймгуудаас элсүүлэх оюутны хяналтын тоог БШУЯ тогтооно.
- 1.5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 1.6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://burtgel.num.edu.mn/docs/> цахим хуудсанд байрлуулна.
- 1.6.1. Элсэлтийн комиссын хаяг, элсэлт авах хөтөлбөр, хуваарь сонгуулах өдөр, цаг, байр болон бусад мэдээллийг Боловсролын үнэлгээний төвөөс ерөнхий шалгалтын (цаашид ЕШ гэж товчилно) дүн, оноо, жагсаалтыг зарламагц МУИС-ийн төв байрны гаднах электрон самбар болон <http://burtgel.num.edu.mn> , www.num.edu.mn цахим хуудсанд байрлуулна.
- 1.7. Бакалаврын зэрэгтэй иргэнийг зарим мэргэжлээр бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсүүлэн суралцуулах бөгөөд бүртгүүлэгчдээс элсэлтийн ЕШ өгсөн байхыг шаардахгүй. Элсэлтийг “МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт 2014 онд оюутан элсүүлэх журам”-аар тусад нь зохион байгуулна. <http://burtgel.num.edu.mn/docs/> цахим хуудас руу хандан энэ журамтай танилцаж болно.
- 1.8. Бакалаврын зэрэгтэй иргэн өдрийн хөтөлбөрөөр суралцаж, бакалаврын боловсрол эзэмших хүсэлтэй бол ЕШ өгсөн байна.
- 1.9. МУИС-д элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэдийн асуудлыг тусад нь журмаар зохицуулна.
- 1.10. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан Элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

2. 2014 онд МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсүүлэх ЕШ

¹МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх ажлыг “Аймаг, орон нутгаас Монголын их дээд сургуулиудын консорциум (МИДСК)-ын гишүүн их дээд сургууль, коллежид 2014 онд оюутан элсүүлэх журам”-ын дагуу МИДСК зохион байгуулна.

- 2.1. Бүртгүүлэгч нь энэ журмын хавсралтад (Хавсралт 1) заасан МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлнэ. Шинжлэх ухааны сургуулийн хувьд Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухаан гэсэн 3 салбараар бүртгүүлнэ. Бүртгүүлэгч хэд хэдэн бүрэлдэхүүн сургууль/салбарт зэрэг бүртгүүлж болно.
- 2.2. МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Хууль зүйн сургууль болон Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль нь хоёр ЕШ-ийн дүнгээр буюу “Суурь” шалгалт-70% , “Дагалдах” шалгалт-30% гэсэн хувилбараар бүртгэнэ.
- 2.3. МУИС-ийн Бизнесийн сургууль нь зөвхөн Математикийн ЕШ-ын оноог үндэслэн бүртгэж элсүүлнэ.
- 2.4. Бүртгүүлэгч нь өөрийн өгсөн элсэлтийн шалгалтуудаас, тухайн сургуулийн/салбарын "Суурь" шалгалтанд нэр заасан ЕШ-аас нэг хичээлийг, “Дагалдах” шалгалтуудаас нэг хичээлийг бүртгэлийн системээс өөрөө сонгоно.
- 2.5. Математик болон Монгол хэлний шалгалтыг 100 хувьд тус тус тооцуулан бүртгүүлж болно.
- 2.6. Хяналтын тоонд багтсан элсэгч зохих шаардлагыг хангасан бол анх бүртгүүлж элссэн тухайн бүрэлдэхүүн сургууль/салбарын бакалаврын бүх үндсэн мэргэжлээс (цаашид хөтөлбөр гэнэ) сонгон суралцах боломжтой. /тус журмын хавсралтын тайлбар 1-ийг үзнэ үү/

3. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

- 3.1. Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх хуваарь дээр нийслэл хотод Ерөнхий боловсролын сургууль (ЕБС) төгссөн болон байнга оршин суугаа иргэн өрсөлдөх эрхтэй. БШУЯ-наас Багануур дүүрэгт МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх хяналтын тоог тусад нь гаргаж баталсан бол энэ дүүрэгт ЕБС төгсөгчид Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх хуваарь дээр өрсөлдөх эрхгүй.
- 3.2. Бүртгүүлэгч нь МУИС-ийн шаардлагатай хичээлээр 2013 эсвэл 2014 онд ЕШ өгсөн байна. /Шалгалт өгөх хичээлийн нэрийг хавсралтаас үзнэ үү/
- 3.3. Бүртгүүлэгч ЕШ-ын оноог ахиулах зорилгоор 2014 онд дахин ЕШ өгсөн тохиолдолд илүү оноотой зөвхөн нэг батламжаар бүртгүүлнэ.
- 3.4. Бүртгүүлэгч МУИС-д бүртгүүлэхээс өмнө ЕШ-ын шалгуулагчийн буланд нэвтэрч өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, хэрэв асуудал байвал шийдвэрлүүлсэн байх шаардлагатай.
- 3.5. Бүртгүүлэгч ЕШ-д БШУЯ-наас баталсан 400 хэмжээст оноо авч МУИС-д бүртгүүлэхэд тавигдах доод шаардлагыг хангасан байна. Энэхүү бүртгэлийн босго оноог журмын 5.3-д заасан аргачлалаар тооцох ба “Суурь” шалгалтын оноо нь 400-аас дээш байна.
- 3.6. Бүртгэлтэй холбоотой төлбөр, тооцоог цахим хэлбэрээр хийнэ. /Цахим картаар төлбөрийг хэрхэн хийх тухай дэлгэрэнгүй зөвлөмж системээс үзнэ үү/
- 3.7. Бүртгүүлэгч нь элсэлттэй холбоотой мэдээллийг хүлээн авах цахим шуудангийн хаягийг бүртгүүлнэ.

4. Элсэлтийн бүртгэл

- 4.1. Элсэлтийн бүртгэлийг зөвхөн цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулна.
- 4.2. Элсэлтийн бүртгэл 2014 оны 7-р сарын 1-4 өдрүүдэд явагдана. Бүртгэлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://burtgel.num.edu.mn> болон www.num.edu.mn цахим хуудсаар мэдээнэ.
- 4.3. Бүртгүүлэгч системд ЕШ-ын бүртгэлийн дугаар, нууц үгээ оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.
- 4.4. Системд амжилттай нэвтэрсэн үед системээс бакалаврын өдрийн хөтөлбөрт бүртгүүлэгчийн хувийн болон ЕШ-ын мэдээллийг дэлгэцэнд харуулах ба асуудал гарвал Элсэлтийн комисс эсвэл Боловсролын үнэлгээний төвд хандаж шийдвэрлүүлнэ.
- 4.5. Бүртгүүлэгч хувийн мэдээллээ баталгаажуулсны дараа бүртгүүлэх боломжтой бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөрийн жагсаалтыг системээс харуулах бөгөөд сонирхсон бүрэлдэхүүн сургууль\салбараа сонгож тэмдэглэнэ.
- 4.6. Бүртгүүлэгч хэдэн ч бүрэлдэхүүн сургууль/салбарт бүртгүүлж болно. Бүртгэлийн хураамж: 1 сургууль/салбарт бүртгүүлбэл 9000 төгрөг, 2 сургууль/салбарт бүртгүүлбэл тус бүр 8000 төгрөг, 3-аас дээш сургууль/салбарт бүртгүүлбэл тус бүр 7000 төгрөг байна.
- 4.7. Бүртгүүлэгч бүртгүүлэхийг хүссэн сургууль/салбарыг сонгосон үед төлбөл зохих нийт төлбөрийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаад төлбөрийг цахим хэлбэрээр хийнэ.

5. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх

- 5.1. БШУ-ны сайдын холбогдох тушаалд нэр заасан улсын болон олон улсын олимпиадад оролцсон. МУИС-д бүртгүүлэхэд тавигдах доод шаардлагыг (ЕШ-ын хэмжээст оноо: 400) хангасан ЕБС төгсөгчийг онооны дараалал харгалзахгүй тухайн чиглэлээр элсүүлэх бөгөөд олимпиадын чиглэл нь элсэх гэж буй сургууль/салбарын суурь шалгалт, мэргэжлийн чиглэлтэй давхцах ёстой. Бизнесийн сургуулийн хувьд зөвхөн Математикийн улсын олимпиадад шагналт байр (I-YI) эзэлсэн бүртгүүлэгч элсэх боломжтой. Сэтгэх чадвар, Уран бичлэг зэрэг ур чадварын олимпиад хөнгөлөлттэй элсэх нөхцөлд хамрагдахгүй. Энэхүү хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх ЕБС төгсөгч “олимпиад” гэсэн сонголтоор бүртгүүлэх ба журмын 4.6-д заасны дагуу бүртгэлийн хураамж төлнө. Элсэгч сургалтын төлбөрөө өөрсдөө хариуцна.
- 5.2. МУИС-ийн харъяа гүнзгийрүүлсэн сургалттай “Байгаль-Эх” ахлах сургуулийг төгсөгч МУИС-д элсэхээр хүсэлт гаргасан тохиолдолд ЕШ-ын хэмжээст оноо нь 520-ийг хангасан нөхцөлд МУИС-аас тогтоосон хяналтын тоонд багтаан гүнзгийрэн судалсан чиглэлээр нь Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуульд онооны дараалал харгалзахгүй элсүүлж болно. Энэхүү хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх “Байгаль-Эх” ахлах сургуулийн төгсөгч журмын 4.6-д заасны дагуу бүртгэлийн хураамж төлнө.
- 5.3. Бүртгүүлэгчийн нийт оноог хавсралтад заасан шалгалтын харьцааг харгалзан тооцож гаргана. Тухайлбал, хөтөлбөр хоёр шалгалттай бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар нэмэх буюу “Суурь” шалгалтанд авсан оноог 0.7-оор, “Дагалдах” шалгалтанд авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ.
- 5.4. Хэмжээст оноо тэнцсэн тохиолдолд гүйцэтгэлийн хувиар байр эзлүүлж элсэх эрх олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

- 5.5. Хяналтын тоонд багтсан эсэхийг бүртгэл хаагдсаны дараа тогтоосон хугацаанд системээр бүртгүүлэгчид мэдэгдэнэ.

6. Элсэх эрх олгох

- 6.1. Бүртгэл эхлэх өдөр буюу 2014 оны 7-р сарын 1 өдрийн 18:00-20:00 цагийн хооронд “Байгаль-Эх” ахлах сургуулийн болон улсын олимпиадын бүртгүүлэгчдэд элсэх эрх олгох ба энэ хугацаанд ирээгүй бүртгүүлэгчийг хөнгөлөлттэй нөхцлөөр элсэх эрхээсээ татгалзсан гэж үзнэ. “Байгаль-Эх” ахлах сургуулийн болон улсын олимпиадын хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх хүсэлтэй хүүхдүүд 2014 оны 7-р сарын 1 өдрийн 18.00 цагаас өмнө системд бүртгүүлэх шаардлагатай. *(Ийнхүү хөнгөлөлттэй нөхцлөөр элсэгчдийн “бүртгэх”, “элсэх эрх” олгох үйл ажиллагаа зөвхөн бүртгэлийн эхний нэг өдөрт явагдана)*
- 6.2. Элсэх эрх олгох үндсэн үйл ажиллагаа хоёр өдөр явагдана. Эхний өдөр буюу 2014 оны 7-р сарын 5 өдрийн 09:00-18:00 цагийн хооронд хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдэд элсэх эрх олгоно. Хэд хэдэн сургуулийн хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг сургуулийг сонгох ба энэ үед бусад сургуулийн хяналтын тооны жагсаалтаас нэр нь хасагдаж босго шугам нэгээр доошилно. Ингэж хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчид энэ талаар системээс мэдэгдэнэ.
- 6.3. Элсэх эрх олгох үйл ажиллагааны хоёр дахь өдөр буюу 2014 оны 7-р сарын 6 өдрийн 9.00-12:00 цагийн хооронд, бүртгүүлэгчдэд элсэх эрх үргэлжлүүлэн олгоно. Хяналтын тоо үлдвэл тус өдрийн 14:00 цагаас хойш бүрэлдэхүүн сургуулийн зарласан цагт бүртгүүлэгч өөрийн биеэр ирж элсэх эрхээ авах бөгөөд бүртгүүлэгчдийг жагсаалтын дээрээс /онооны дарааллаар/ эхлэн нэр дуудаж элсэх эрх өгнө. Зарласан цагт нэрийг нь дуудахад байхгүй бол онооны дарааллаар дараагийн хүнд сонголтыг шилжүүлнэ. Элсэх эрх олгох үед хоцорсон бүртгүүлэгч ирсэн даруйдаа үлдсэн хуваариас онооны дарааллаар сонгох эрхтэй.
- 6.3. Бүртгүүлэгч элсэх эрхээ авахдаа дараах материалыг бүрдүүлж өөрийн биеэр ирнэ. Үүнд:
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрэнд) хамт
 - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг)
 - ЕШ-ын батламж, хуулбарын хамт
 - Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхний шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан) Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
 - Журмын 5.1-р заалтаар бүртгүүлэгч нь олимпиадад оролцсоныг гэрчлэх бичиг баримтын эх хувь, тэдгээрийн хуулбарын хамт авч ирнэ.
- 6.4. Элсэх эрх олгох үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.

7. Бусад

- 7.1. Элсэгч элсэх эрхээ буцаах тохиолдолд нэг багц цагийн үнэлгээний хэмжээний төлбөр төлнө.
- 7.2. Нэг бүрэлдэхүүн сургуулиас нөгөө бүрэлдэхүүн сургуульд шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэх боломжгүй.
- 7.3. Элсэх эрхийг баталгаажуулах бүртгэл 2014 оны 8-р сарын 22-24 өдрүүдэд явагдана. Энэ баталгаажуулах бүртгэлийн үед элсэгчдэд МУИС-ийн мэдээллийн системийг ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг өгнө. Элсэгч энэхүү эрхээ ашиглан эхний

улирлын сургалтын суурь хураамж болон судлах хичээлийн багц цагийн төлбөрийг онлайнаар (цахим картаар) төлсний дараа оюутнаар элсүүлэх тушаалыг гаргана.

- 7.4. Элсэх эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй хүнийг суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийн бичгийг хүчингүйд тооцно.
- 7.5. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг МУИС-д элсүүлэхгүй, хуурамч бичиг баримтаар элссэн нь тогтоогдсон тохиолдолд хасна.
- 7.6. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.
- 7.7. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, мессенжер болон цахим шуудангаар зохион байгуулна.

Журмын хавсралт

**МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2014 онд
Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх журмын хавсралт**

№	МУИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ	СОНГОХ БОЛОМЖТОЙ БАКАЛАВРЫН ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР ²	ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ	
			“Суурь” шалгалт (70%)	“Дагалдах” шалгалт (30%)
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	Матемтик	- Математик¹⁰⁰ - Физик - Хими - Биологи	- Математик - Физик - Хими - Биологи - Газарзүй - Монгол хэл - Англи хэл - Орос хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг
		Багш, математикийн		
		Багш, байгалийн ухааны боловсрол		
		Физик		
		Геофизик		
		Хими		
		Биологи		
		Биохими		
		Биологийн нөөц судлал		
		Экологи		
		Газарзүй		
		Геологи		
		Байгаль орчныг зайнаас тандан судлал		
		Хот ба бүс нутгийн төлөвлөлт		
		Биотехнологи		
		Газар зохион байгуулалт		
2	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	Эдийн засаг	- Нийгмийн тухай мэдлэг - Монголын түүх - Математик¹⁰⁰	- Математик - Физик - Хими - Биологи - Газарзүй - Монгол хэл - Англи хэл - Орос хэл - Монголын түүх - Нийгмийн тухай
		Сэтгүүл зүй		
		Улс төр судлал		
		Сэтгэл судлал		
		Социологи		
		Нийгмийн ажил		
		Антропологи		
		Архив судлал		

²МУИС-ийн Бакалаврын сургалтын журамтай дараах хаягаар орж танилцана уу? www.num.edu.mn

				мэдлэг
	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГ ИЙН УХААНЫ САЛБАР	Түүх Археологи Философи Шашин судлал Хэл, уран зохиол Хэл шинжлэл Утга зохиол судлал Урлаг судлал Олон улс, орон судлал Багш, монгол хэл- уран зохиолын боловсрол Багш, нийгмийн ухааны боловсрол Багш, гадаад хэлний боловсрол Гадаад хэлний орчуулга	- Монгол хэл¹⁰⁰ - Англи хэл - Орос хэл - Нийгмийн тухай мэдлэг - Монголын түүх	- Математик - Физик - Хими - Биологи - Газарзүй - Монгол хэл - Англи хэл - Орос хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг
	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧ ЛЭЛИЙН СУРГУУЛЬ	Статистик Хэрэглээний математик Хэрэглээний хими Химийн инженерчлэл Компьютерийн ухаан Компьютерийн сүлжээ Мэдээллийн технологи Програм хангамж Мэдээллийн систем Холбооны технологи Сэргээгдэх эрчим хүч Электрон системийн автоматжуулалт Цөмийн инженерчлэл Материал судлал Био-инженерчлэл Нано шинжлэх ухаан, инженерчлэл Байгаль орчныг хамгаалах технологи Ойн үйлдвэрлэлийн техник, технологи Хүрээлэн буй орчин судлал Цаг уур Ус судлал	- Математик¹⁰⁰ - Физик - Хими - Биологи	- Математик - Физик - Хими - Биологи - Газарзүй - Монгол хэл - Англи хэл - Орос хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг
5	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	Нягтлан бодох бүртгэл Санхүү, банк Даатгал Бизнесийн удирдлага Менежмент Маркетинг Худалдаа Зочлох үйлчилгээ Аялал жуулчлал	Математик-100%	

6	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	Эрх зүй	Нийгмийн тухай мэдлэг	Математик
7	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	Олон улсын харилцаа	- Англи хэл - Орос хэл - Нийгмийн тухай мэдлэг	- Англи хэл - Орос хэл - Монгол хэл - Монголын түүх - Математик - Нийгмийн тухай мэдлэг
		Нийтийн удирдлага		

Тайлбар:

- МУИС-д элсэхийг хүссэн иргэн хавсралтанд заасан бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэх бөгөөд ЭЕШ-ын шалгалтын оноогоороо элсэлтийн хяналтын тоонд багтсан тохиолдолд МУИС-ийн оюутан болж элсэх эрхтэй болно. Элсэгч нь тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын бүх мэргэжлээс сонгон суралцах бололцоотой бөгөөд эхний хичээлийн жилийн (1 болон 2 дугаар улирал) сурлагын дүн, анх элсэхээр бүртгүүлэхдээ тооцуулсан ЭЕШ-ийн оноо өндөр байх тусам мэргэжил сонгохдоо давуу эрх эдэлнэ. Жишээлбэл, ШУС-ийн Байгалийн ухааны салбарт бүртгүүлэн элссэн оюутан тус бүрэлдэхүүн сургуулийн байгалийн ухаан төдийгүй нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны салбарын бүх хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой болно. Ингэхдээ эхний жилийн хичээлүүдийг судалсан сурлагын амжилт, анх бүртгүүлсэн ЭЕШ-ийн оноогоороо ШУС-ийн оюутнууд жагсаж онооны нийлбэр нь хамгийн өндөр оюутан бүх мэргэжлээс эхэлж сонгох боломжтой болох юм. Мөн түүнчлэн зарим хөтөлбөрийн хувьд бэлтгэж буй мэргэжил, шинжлэх ухааны онцлогоос үүдсэн тусгай шаардлага тавигдана.
- МУИС-д элссэн оюутан нь өөрийн сонгосон үндсэн мэргэжлээс гадна МУИС-ийн санал болгох “Хавсарга” мэргэжлээс сонгон судалж, “Үндсэн мэргэжил”, “Хавсарга мэргэжил” эзэмших боломжтой болно. Жишээлбэл, ШУС-д Физик мэргэжлээр суралцаж байгаа оюутан Бизнесийн сургуулийн Маркетинг-аар хавсарга мэргэжил эзэмших боломжтой.
- ¹⁰⁰ -гэсэн тэмдэглэгээтэй “Суурь” шалгалтын хувьд: Математик, Монгол хэлний шалгалтын оноог бүтэн буюу 100% тооцуулж болно. Өөрөөр хэлбэл, хэрэв бүртгүүлэгч өөрөө хүсвэл Математикийн шалгалтыг 100 хувь гэж тооцуулж, “Дагалдах” шалгалт сонгохгүй байх боломжтой. Энэ нь зөвхөн Математик, Монгол хэлний “Суурь” шалгалтын тухайд хүчинтэй байна.

Монгол Улсын Их Сургууль
2014 он